



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫНДАРГЫНТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга: С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер:
С.Оюунгэрэл
Утас: 260512

Аудитор: И.Туяа
Утас: 261885

Монгол Улсын Үндэсний аудитын газар

Монгол Улс
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.audit.mn
Цахим хаяг: info@audit.gov.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн
санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хавсралт 4: Жилийн төсвийн гүйцэтгэлийн
нэгтгэсэн тайлан

Оршил

Авлигатай тэмцэх газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусгавар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

2013 оны төсөвт зардал 11,283.0 сая төгрөгөөр батлагдсанаас 11,093.2 сая төгрөг буюу 98.3 хувийг зарцуулсан байна.

Нийт төсөвт зардлын 37.1 хувийг эрдэм шинжилгээний ажил, 27.3 хувийг цалин, хөлс, НДШ, 27.5 хувийг хөрөнгө оруулалт, 8.1 хувийг бараа, үйлчилгээний зардал эзэлж байна.

Төв төрийн сангаас батлагдсан төсвийн хуваарьт сар бүрийн зарцуулалтын эрхийн хүсэлт баталгааг үндэслэн харилцах дансанд бодит гүйцэтгэлээр буюу 11,266.4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн ба акталсан бараа материал, үндсэн хөрөнгийг худалдсанаас 1.8 сая, нийт 11,268.2 сая төгрөгийн орлого орсноос 11,093.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, зарцуулагдаагүй үлдэгдэл 175.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2013 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаар 8,468.7 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй илэрхийлэгдсэнээс 77.7 хувь буюу 6,582.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 10.9 хувь буюу 927.2 сая төгрөгийн авлага болон урьдчилгаа, 9.9 хувь буюу 838.9 сая төгрөгийн бараа материал, 1.5 хувь буюу 120.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн 28.2 хувийг барилга байгууламж, 65 хувийг тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, 3.7 хувийг тавилга эд хогшил, 3.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд: Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон Сангийн яамнаас гаргасан заавар, журмын хэрэгжилт, бүртгэлээр тавих хяналт хангалттай ба харин төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл байна.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг удирдлагын анхааралд хандуулж байна.

Төсвийн төлөвлөлтийн талаар

Тус газар тухайн жилийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэрэгцээгээ 11,329.2 сая төгрөгөөр тодорхойлон, УИХ-д санал хүргүүлсэн ба УИХ-аар АТГ-ын 2013 оны тодотгосон төсвийг 11,283.0 сая төгрөгөөр буюу анх төсөвлөснөөс 46.2 сая төгрөгөөр /үндсэн цалинг/ бууруулж баталсан байна.

Төсвийн төлөвлөлтийг хэлтэс, албадуудын тооцоо, судалгааны үндсэн дээр бодитой тодорхойлсон ба Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2:-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох” гэснийг баримталж ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын талаар

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил, гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналтай тулган шалгахад: 2013 онд хөрөнгө оруулалтын зардалд 3,001.4 сая төгрөг батлагдсанаас 2,984.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 16.6 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтаар 5,152.6 сая төгрөгийн ажил, гүйлгээ бүртгэгдсэний 2,167.8 сая төгрөг нь урьд оны хөрөнгийн санхүүжилт ба үндсэн хөрөнгийн дансанд 3,152.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, нэр бүхий албан хаагчдад 2,000.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгийн тодруулга тайлантай танилцахад: үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 5,429.8 сая, тайлант хугацаанд 4,154.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,868.8 сая төгрөгөөр хасагдсан ба элэгдлийн зардал 1,133.3 сая төгрөг гарч, оны эцэст 6,582.5 сая төгрөгийн хөрөнгөтэй байна.

Үндсэн хөрөнгийн тодруулга тайланг шалгахад: Тайлант хугацаанд Дэлхийн банкнаас хандиваар 83.7 сая төгрөгийн хөрөнгө орлогын мэдүүлгийн програм хангамж, хөрөнгө оруулалтаар 3,965.4 сая төгрөгийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, балансаас балансад 105.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, биет бус хөрөнгүүд шилжиж ирсэн ба нийт 4,154.8 сая төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн, ТӨХ-ны 2013.3.4-ний өдрийн 3/489 дүгээр тогтоолоор 523.2 сая төгрөгийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил худалдсан, мөн оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 3/2641 дүгээр тогтоолоор 105.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж, 1,240.6 сая төгрөгийн дуусаагүй барилга байгууламжийг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн ба нийт 1,868.8 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Төсөвт зардлын талаар

2013 онд төсөвт зардал 11,283.0 сая төгрөгөөр батлагдсанаас, 11,093.2 сая төгрөгийг зарцуулж, нийт батлагдсан төсөвт зардал 189.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн үзүүлэлттэй бараа, үйлчилгээний зардлын ангиллаар авч үзэхэд: төсөвт зардлыг 241.8 сая төгрөгөөр хэмнэж, 51.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн ба Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу бараа үйлчилгээний зардлын бүлэглэл хооронд зохицуулалт хийгдсэн байна.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг АТГ-ын удирдлага болон дотоод аудитын нэгж авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай ба аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар тохиролцсон тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар

Нийт төсвийн гүйцэтгэл 11,093.2 сая төгрөгөөс, 4,388.7 сая төгрөгийн ажил, гүйлгээг түүвэрлэн авч, түүнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлтийг шалгахад: Батлагдсан төсөвт зардлаас 41.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д: “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтыг баримталж ажиллаагүйтэй холбоотой байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн ба уг аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Авлигатай тэмцэх газрын даргын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-86

2014.04.25 № 667

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Авлигатай тэмцэх газрын удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

675233

Тамгын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Авлигатай тэмцэх газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Тамгын газар-А4 бланк

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН
2013 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2

**Асуудал 1 Төсвийн хөрөнгийн
зарцуулалтын талаар**

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь АТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан Ерөнхий менежер бөгөөд Тамгын хэлтсийн дарга, Эрхэлсэн комиссар Б.Доньжчимбуу, Ерөнхий нягтлан бодогч, Ахлах комиссар Д.Батмөнх болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

Асуудал 1 Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Батлагдсан төсөвт зардлаас 41.4 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь дотоод журамын холбогдох заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсөвт зардлыг үр ашигтай зарцуулахад анхаарч ажиллах

Эрсдэл

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх \Э, Иж, Үз, Х\

Үйлчлүүлэгчийн хариу

Холбогдох албан тушаалтнуудад асуудлын бүртгэлийг танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх Үзүүлэлт	/ төгрөгөөр/	
	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Хөрөнгө	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	69,164,570.00	120,164,570.00
Авлага	6,302,257.20	4,200,043.00
Урьдчилгаа тооцоо	228,044,322.00	922,992,279.60
Бараа материал	761,280,180.23	838,876,960.60
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	1,064,791,329.43	1,886,233,853.20
Эргэлтийн бус хөрөнгө		
Биет хөрөнгө	5,396,727,453.87	6,458,163,728.05
Биет бус хөрөнгө	33,137,634.32	124,387,328.62
Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн	5,429,865,088.19	6,582,551,056.67
Хөрөнгийн нийт дүн	6,494,656,417.62	8,468,784,909.87
Өр төлбөр		-
Өглөг	655,000.00	-
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	655,000.00	-
Өр төлбөрийн нийт дүн	655,000.00	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт		
Засгийн газрын оруулсан капитал	1,489,727,611.81	1,489,727,611.81
Хуримтлагдсан үр дүн	5,004,273,805.81	6,979,057,297.86
Өмнөх үеийн үр дүн		5,004,273,805.61
Тайлант үеийн үр дүн		1,974,783,492.25
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нийт дүн	6,494,001,417.62	8,468,784,909.67
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нийт дүн	6,494,656,417.62	8,468,784,909.67

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх		/ төгрөгөөр /
Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-
Олон улсын байгууллагын тусламж	-	83,702,786.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,357,221,233.44	8,281,637,000.00
Хөрөнгийн санхүүжилт	985,445,382.00	2,984,789,691.00
Урьд оны төсвийн хөрөнгө оруулалт	-	112,654,618.00
Нэмэлт санхүүжилт	-	7,848,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	118,318,925.69	88,770,990.19
Үндсэн үйл ажиллагааны орлогын нийт дүн	8,460,985,541.13	11,559,403,085.19
Үндсэн үйл ажиллагааны зардал		
Цалин, хөлс болон ажиллагсдын тэтгэмж	2,232,921,726.92	3,027,257,757.11
Бараа үйлчилгээний зардал	2,570,551,230.60	4,989,375,966.87
Татаас болон шилжүүлгийн төлбөр	512,633,451.48	175,089,569.35
Нийгмийн хамгааллын зардал	46,666,134.00	71,615,760.00
Элэгдэл, хорогдлын зардал	714,807,175.97	1,279,240,038.69
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	6,077,579,718.97	9,542,579,092.02
Үндсэн үйл ажиллагааны нийт үр дүн	2,383,405,822.16	2,016,823,993.17
Үндсэн хөрөнгө худалдсаны олз/гарз	-	(42,040,500.92)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого (зардал)-ын нийт дүн	-	(42,040,500.92)
Тайлант үеийн үр дүн	2,383,405,822.16	1,974,783,492.25

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх	/ төгрөгөөр /	
Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,357,221,233.44	8,281,637,000.00
Барьцаа, баталгааны орлого	53,087,500.00	51,000,000.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт	-	2,984,789,691.00
Урьд оны хөрөнгө оруулалт	-	112,654,618.00
Нэмэлт санхүүжилт	-	7,848,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4,816,555.00	1,859,844.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	7,415,125,288.44	11,439,789,153.00
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин, хөлс болон ажиллагсдын тэтгэмж	2,231,899,575.92	3,027,045,295.11
Бараа үйлчилгээний зардал	2,884,528,640.84	2,812,722,696.54
Хөтөлбөр арга хэмжээний зардал	103,230,883.00	149,777,542.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	512,633,451.48	175,089,569.35
Нийгмийн хамгааллын зардал	46,666,134.00	71,615,760.00
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	5,778,958,685.24	6,236,250,863.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,636,166,603.20	5,203,538,290.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт	1,850,980,353.93	2,634,219,506.00
Хөрөнгө оруулалт худалдан авалт	-	2,518,318,784.00
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	1,850,980,353.93	5,152,538,290.00
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(214,813,750.73)	51,000,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	283,978,320.73	69,164,570.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	69,164,570.00	120,164,570.00

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх				/ төгрөгөөр /
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,537,884,974.00	-	2,620,867,983.65	4,158,752,957.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(48,157,362.19)	-	-	(48,157,362.19)
Тайлант үеийн үр дүн	-	-	2,383,405,822.16	2,383,405,822.16
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,489,727,611.81	-	5,004,273,805.81	6,494,001,417.62
2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,489,727,611.81	-	5,004,273,805.81	6,494,001,417.62
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт		-	-	
Тайлант үеийн үр дүн	-	-	1,974,783,492.25	1,974,783,492.25
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,489,727,611.81	-	6,979,057,298.06	8,468,784,909.87

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх	/ төгрөгөөр /				
	Зардлын нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		69,164,570.00			
Нийт зарлага ба цэвэр зээл	11,283,037,000.00	11,093,196,965.65	189,840,034.35	98	
Үндсэн цалин	2,712,993,300.00	2,624,458,591.36	88,534,708.64	97	
Унаа, болон бусад нөхөн олговор	101,556,000.00	100,816,800.00	739,200.00	99	
Нийгмийн даатгалын шимтгэл	323,718,900.00	301,769,903.75	21,948,996.25	93	
Гэрэл цахилгааны зардал	17,562,100.00	20,332,294.00	(2,770,194.00)	116	
Түлш, халаалтын зардал	12,899,200.00	13,809,134.50	(909,934.50)	107	
Цэвэр, бохир усны зардал	4,435,800.00	3,674,992.33	760,807.67	83	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	56,688,800.00	35,789,508.00	20,899,292.00	63	
Байрны түрээсийн зардал	34,781,000.00	30,266,000.00	4,515,000.00	87	
Бичиг хэргийн зардал	29,069,500.00	30,511,058.00	(1,441,558.00)	105	
Тээвэр, шатахууны зардал	62,199,000.00	62,768,240.00	(569,240.00)	101	
Шуудан, харилцаа холбоо	66,090,000.00	65,928,149.39	161,850.61	100	
Дотоод албан томилолт	101,340,400.00	97,857,669.60	3,482,730.40	97	
Гадаад албан томилолт	91,049,000.00	74,381,779.00	16,667,221.00	82	
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	4,903,000.00	3,957,254.00	945,746.00	81	
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	9,430,500.00	6,816,800.00	2,613,700.00	72	
Сургалт семинарын зардал	15,675,000.00	15,767,952.80	(92,952.80)	101	
Эрдэм шинжилгээний ажил хийх	4,114,721,400.00	4,114,721,400.00	-	100	
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэлийн зардал	270,000.00	240,000.00	30,000.00	89	
Төлбөр хураамж, жижиг татварууд	167,130,900.00	125,393,985.00	41,736,915.00	75	
Урсгал засварын зардал	18,175,000.00	17,625,190.00	549,810.00	97	
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2,140,000.00	960,000.00	1,180,000.00	45	
Гадаадын зочны зардал	19,730,000.00	36,066,798.00	(16,336,798.00)	183	
Газрын төлбөр	1,935,000.00	2,304,644.00	(369,644.00)	119	
Хог хаягдал устгах зардал	1,680,000.00	1,680,000.00	-	100	
Мэдээлэл, сурталчилгааны ажил (гадаад, дотоод)	102,738,100.00	114,772,940.00	(12,034,840.00)	112	
Тоног төхөөрөмж худалдан авсан	821,400,000.00	812,921,185.00	8,478,815.00	99	
Хөрөнгө оруулалт их засвар	180,000,000.00	171,868,506.00	8,131,494.00	95	
Орон сууцны дэмжлэг	2,000,000,000.00	2,000,000,000.00	-	100	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	37,976,000.00	35,826,252.00	2,149,748.00	94	
Багаж хэрэгсэл	26,837,300.00	17,309,048.63	9,528,251.37	64	
Тавилга эд хогшил	62,200,000.00	57,992,668.29	4,207,331.71	93	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	95,000.00	-	95,000.00	-	
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	18,130,700.00	33,518,961.00	(15,388,261.00)	185	
Програм хангамж худалдан авсан	17,000,000.00	15,441,459.00	1,558,541.00	91	
Тээврийн хэрэгслийн даатгал	8,454,100.00	10,489,950.00	(2,035,850.00)	124	

ТӨГАҮ \Гэнэтийн осолын даатгал\	8,032,000.00	8,001,250.00	30,750.00	100
Төрийн албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх зардал	30,000,000.00	27,156,602.00	2,843,398.00	91
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр:	11,283,037,000.00	11,319,286,535.00		100
Урсгал зардлын санхүүжилтээс	8,281,637,000.00	8,281,637,000.00		100
Хөрөнгийн орлогоос	3,001,400,000.00	2,984,789,691.00		99
Барьцааны орлогоос		51,000,000.00		-
Туслах үйл ажиллагааны орлогоос		1,859,844.00		-
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		120,164,570.00		-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		175,089,569.35		
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагчид бүгд	145	143		
Удирдах ажилтан	15	15		
Гүйцэтгэх ажилтан	120	120		
Үйлчлэх ажилтан	10	8		
Гэрээт ажилтан				